

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/170/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхтогтох Утас: 70453721, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ХЯРГАС СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Д.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

2022.02.25 № УВА-2022/170/НА-СТА/ТЦЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хяргас сумын Эрүүл мэндийн төв нь төрийн албан хаагчийн мөнгөн урамшуулал болон ковид-19 цар тахалтай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 377/А99 дугаар тушаалаар олгосон илүү цагийн нэмэгдлийг 22 ажилтанд 7,502.3 мянган төгрөгийг олгохдоо Нийгмийн даатгалын тухай хуулийн 15.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 14 дүгээр зүйлийн 14.1. дэх заалтад “Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна” гэж заасныг зөрчин нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар суутгаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага

0200200556

ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Зам, тээврийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар баталсан жишиг нормыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил 4630.5 мянган төгрөгийн 1890 литр шатах тослох материалыг олгоходоо жагсаалт үйлдээгүй, зарцуулахдаа замын хуудас хөтлөөгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй хяналтгүйгээр зарцуулсан, Төсвийн тухай хуулийн 5.1.5 “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтад нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	1
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан	5
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

2.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>61,878,157.58</u>	<u>147,591,430.15</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	4,284,997.58
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	4,284,997.58
3121	Төгрөг	00.00	4,284,997.58
31211	Төрийн сангийн харилцах	00.00	3,330,747.58
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	954,250.00
33	АВЛАГА	2,886,751.00	75,204,986.97
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	68,044,720.00
335	Бусад авлага	2,886,751.00	7,160,266.97
3351	Байгууллагаас авах авлага	2,886,751.00	7,160,266.97
35	БАРАА МАТЕРИАЛ	58,991,406.58	68,101,445.60
351	Түүхий эд материал	10,564,375.00	11,171,672.00
35130	Эм боох материал	10,564,375.00	11,171,672.00
354	Хангамжийн материал	48,427,031.58	56,929,773.60
35410	Бичиг хэргийн материал	1,693,750.00	867,100.00
35420	Аж ахуйн материал	29,519,443.52	30,992,583.84
35430	Сэлбэг хэрэгсэл	4,449,835.00	11,826,235.00
35440	Түлш, шатах тослох материал	2,625,580.00	01.00
35450	Барилгын засварын материал	2,004,100.00	2,004,100.00
35460	Хүнсний материал	1,925,362.06	2,663,392.76
35470	Бусад хангамжийн материал	6,208,961.00	8,576,361.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>682,654,082.83</u>	<u>731,805,729.81</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	682,654,082.83	731,805,729.81
392	Биет хөрөнгө	661,614,082.83	710,765,729.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	599,664,291.11	599,664,291.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	-21,224,142.84	-32,488,214.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	72,386,434.00	91,250,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-22,644,253.23	-16,047,333.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	84,415,999.40	105,880,999.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-59,947,106.69	-76,599,118.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,178,311.40	46,193,261.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,871,018.19	-34,319,024.31
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,854,715.00	38,364,715.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,199,147.13	-11,133,847.02
393	Биет бус хөрөнгө	21,040,000.00	21,040,000.00
39301	Програм хангамж	440,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-440,000.00	-440,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,040,000.00	21,040,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>744,532,240.41</u>	<u>879,397,159.96</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3,566,740.30</u>	<u>1,218,355.88</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,566,740.30	1,218,355.88
413	Өглөг	3,566,740.30	1,218,355.88
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,696,010.42	602,009.00
4136	Бусад өглөг	1,870,729.88	616,346.88
41361	Байгууллагад төлөх өглөг	1,870,729.88	616,346.88
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>740,965,500.11</u>	<u>878,178,804.08</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	740,965,500.11	878,178,804.08

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	245,956,542.95	245,956,542.95
51101	Өмч: - төрийн	245,956,542.95	245,956,542.95
512	Хуримтлагдсан үр дүн	169,246,761.51	306,460,065.48
51210	Өмнөх үеийн үр дүн	169,246,761.51	169,246,761.51
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	137,213,303.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	325,762,195.65	325,762,195.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>744,532,240.41</u>	<u>879,397,159.96</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	434,101,632.00	794,682,025.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,900,000.00	88,820,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	34,500,000.00	88,820,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,500,000.00	88,820,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	10,250,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,500,000.00	78,570,000.00
122	Тусламжийн орлого	400,000.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	400,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	399,201,632.00	705,862,025.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	329,208,600.00	390,201,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	329,208,600.00	390,201,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,997,100.00	191,098,180.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,337,100.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	660,000.00	191,098,180.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,890,900.00	32,729,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,890,900.00	32,729,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	26,105,032.00	91,832,645.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	26,105,032.00	91,832,645.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	433,943,416.91	649,867,945.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	433,943,416.91	649,867,945.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,078,939.37	617,107,086.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	273,260,372.00	333,604,667.42
210101	Үндсэн цалин	266,499,767.00	333,253,917.42
210104	Урамшуулал	4,599,435.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,161,170.00	350,750.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,113,949.00	51,787,657.61
210201	Тэтгэврийн даатгал	23,185,678.00	42,853,062.61
210202	Тэтгэмжийн даатгал	2,640,488.00	1,839,315.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,276,436.00	2,219,251.00
210204	Ажилгүйдлийн даатгал	546,484.00	867,878.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,464,863.00	4,008,151.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,006,542.46	30,368,440.70
210301	Гэрэл, цахилгаан	2,899,975.46	2,659,777.70
210302	Түлш, халаалт	25,106,567.00	27,708,663.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,836,512.00	43,433,388.68
210401	Бичиг хэрэг	5,113,110.00	11,454,509.68
210402	Тээвэр, шатахуун	15,868,650.00	30,382,479.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,390,000.00	1,225,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,500.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,302,252.00	370,600.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	912,000.00	00.00
2105	Нормативт зардал	26,670,730.60	102,154,014.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,276,449.00	90,376,890.00
210502	Хоол, хүнс	6,764,281.60	11,777,124.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	630,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,553,600.00	1,768,390.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,200,000.00	00.00
210604	Урсгал засвар	353,600.00	1,768,390.00
2107	Томилолт, зочны зардал	794,000.00	364,000.00
210702	Дотоод албан томилолт	794,000.00	364,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,168,967.00	1,251,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	184,800.00	860,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	166,675.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,500.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	238,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	432,000.00	00.00
210807	Газрын төлбөр	152,992.00	153,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,674,266.31	52,375,027.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	252,000.00	1,737,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,422,266.31	50,637,527.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	864,477.54	32,760,859.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	32,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	32,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	864,477.54	560,859.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	158,215.09	144,814,079.06
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	7,600,775.09
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	7,600,775.09
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-7,600,775.09
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	158,215.09	137,213,303.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	399,201,632.00	637,817,305.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	399,201,632.00	637,817,305.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	329,208,600.00	390,201,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	329,208,600.00	390,201,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,997,100.00	191,098,180.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,337,100.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	660,000.00	191,098,180.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,890,900.00	32,729,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,890,900.00	32,729,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	26,105,032.00	23,787,925.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	26,105,032.00	23,787,925.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	399,201,632.00	633,532,307.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	399,201,632.00	633,532,307.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	398,337,154.46	600,771,448.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	273,726,700.00	343,048,054.84
210101	Үндсэн цалин	245,163,300.00	304,997,100.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,808,000.00	5,122,790.00
210104	Урамшуулал	18,135,400.00	27,888,174.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,620,000.00	5,039,990.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,715,900.00	44,828,287.58
210201	Тэтгэврийн даатгал	22,926,800.00	32,879,099.44
210202	Тэтгэмжийн даатгал	2,697,300.00	2,987,299.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,158,300.00	2,389,789.85
210204	Ажилгүйдлийн даатгал	539,000.00	597,498.62
210205	Эрүүл мэндийн даатгал	5,394,500.00	5,974,599.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,006,542.46	30,368,440.70
210301	Гэрэл, цахилгаан	2,899,975.46	2,659,777.70
210302	Түлш, халаалт	24,786,567.00	27,708,663.00
210303	Цэвэр, бохир ус	320,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,214,550.00	40,722,280.00
210401	Бичиг хэрэг	1,250,000.00	2,757,850.00
210402	Тээвэр, шатахуун	15,868,950.00	29,249,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,720,000.00	1,475,800.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	975,600.00	1,820,580.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	5,418,150.00
2105	Нормативт зардал	31,159,995.00	106,644,885.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,460,100.00	82,048,740.00
210502	Хоол, хүнс	6,499,895.00	14,498,645.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,200,000.00	10,097,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,732,500.00	31,384,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,773,000.00	14,350,000.00
210602	Тавилга	00.00	7,599,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	451,500.00	700,000.00
210604	Урсгал засвар	2,508,000.00	8,735,100.00
2107	Томилолт, зочны зардал	794,000.00	364,000.00
210702	Дотоод албан томилолт	794,000.00	364,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,168,967.00	1,111,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	184,800.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	161,175.00	183,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	54,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	432,000.00	432,000.00
210807	Газрын төлбөр	152,992.00	153,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,818,000.00	2,299,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,818,000.00	2,299,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	864,477.54	32,760,859.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	32,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	32,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	864,477.54	560,859.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	4,284,997.58
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	4,284,997.58
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	4,284,997.58

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн / төгрөгөөр /
C01	2020 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	245,956,542.95	325,762,195.65	169,246,761.51	740,965,500.11
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00

C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	245,956,542.95	325,762,195.65	169,246,761.51	740,965,500.11
D01	2021 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	245,956,542.95	325,762,195.65	169,246,761.51	740,965,500.11
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	245,956,542.95	325,762,195.65	169,246,761.51	740,965,500.11
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	137,213,303.97	137,213,303.97
D09	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	245,956,542.95	325,762,195.65	306,460,065.48	878,178,804.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	448,911,000.00	442,827,518.12	6,083,481.88	98.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	448,911,000.00	442,827,518.12	6,083,481.88	98.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	448,911,000.00	442,827,518.12	6,083,481.88	98.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298,727,700.00	296,507,054.42	2,220,645.58	99.3
210101	Үндсэн цалин	260,676,500.00	258,456,100.42	2,220,399.58	99.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,808,000.00	5,122,790.00	685,210.00	88.2
210104	Урамшуулал	27,203,200.00	27,888,174.00	-684,974.00	102.5
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,039,990.00	10.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,328,300.00	40,328,288.00	12.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	28,379,100.00	28,379,099.44	0.56	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,987,300.00	2,987,299.89	0.11	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,389,800.00	2,389,789.85	10.15	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	597,500.00	597,499.04	0.96	100.0

210205	Эрүүл мэндийн даатгал	5,974,600.00	5,974,599.78	0.22	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,929,300.00	30,368,440.70	560,859.30	98.2
210301	Гэрэл, цахилгаан	2,900,000.00	2,659,777.70	240,222.30	91.7
210302	Түлш, халаалт	27,709,300.00	27,708,663.00	637.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	320,000.00	00.00	320,000.00	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	29,592,900.00	28,658,030.00	934,870.00	96.8
210401	Бичиг хэрэг	2,060,000.00	2,058,650.00	1,350.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	19,732,900.00	19,732,050.00	850.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	1,425,800.00	374,200.00	79.2
210404	Ном, хэвлэл	100,000.00	00.00	100,000.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.00	1,820,580.00	1,379,420.00	56.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,700,000.00	3,620,950.00	-920,950.00	134.1
2105	Нормативт зардал	36,230,300.00	36,190,705.00	39,595.00	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,230,300.00	24,194,560.00	35,740.00	99.9
210502	Хоол, хүнс	7,500,000.00	7,498,645.00	1,355.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,500,000.00	4,497,500.00	2,500.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	1,150,000.00	364,000.00	786,000.00	31.7
210702	Дотоод албан томилолт	1,150,000.00	364,000.00	786,000.00	31.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,621,800.00	1,111,500.00	510,300.00	68.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	00.00	300,000.00	0.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	288,000.00	72,000.00	80.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,100.00	00.00	105,100.00	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	54,800.00	33,200.00	62.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,330,700.00	2,299,500.00	1,031,200.00	69.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,330,700.00	2,299,500.00	1,031,200.00	69.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	25,979,800.00	23,787,925.00	2,191,875.00	91.6
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	25,979,800.00	23,787,925.00	2,191,875.00	91.6
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	3,330,747.58		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00		
620001	Удирдах ажилтан	01.00	01.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00		
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00		
620004	Гэрээт ажилтан	01.00	01.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	өмнөх оны	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		190,143,930.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		190,143,930.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		157,943,930.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		51,041,000.00
210101	Үндсэн цалин		46,541,000.00
210104	Урамшуулал		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,500,000.00
210201	Тэтгэврийн даатгал		4,500,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
2104	Хангамж, бараа материалын зардал		12,064,250.00
210401	Бичиг хэрэг		699,200.00
210402	Тээвэр, шатахуун		9,517,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,797,200.00
2105	Нормативт зардал		70,454,180.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		57,854,180.00
210502	Хоол, хүнс		7,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		5,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		24,384,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		9,850,000.00
210602	Тавилга		7,599,400.00
210604	Урсгал засвар		6,935,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	32,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		32,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		32,200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	191,098,180.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		191,098,180.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		191,098,180.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		954,250.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хяргас сумын Эрүүл мэндийн төв нь Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 4,339.4 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 649,867.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,489.6 мянган төгрөгийн 80 хувиар буюу 5,198.9 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цагалбарт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 142,465.6 мянган төгрөгөөр буюу 19.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	4,284.9	4,284.9
Авлага	2,886.7	75,204.9	72,318.2
Бараа материал	58,991.4	68,101.4	9,110.0
Үндсэн хөрөнгө	682,654.1	731,805.7	49,151.6
Нийт хөрөнгө	744,532.2	879,397.2	134,865.0
Өр төлбөр	3,566.7	1,218.3	-2,348.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	740,965.5	878,178.8	137,213.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	744,532.2	879,397.2	134,865.0

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4,284.9 мянган төгрөг болж 4,284.9 мянган төгрөгөөр өссөн нь үлдэгдэл төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 75,204,9 мянган төгрөг болж 72,318.2 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт дутуу ирснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 68,101.4 мянган төгрөг болж 9,110.0 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлаас шалтгаалан аж ахуйн материал, эм боох

материал нэмэгдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Оны эцэст бараа материалын нөөц үүсгэсэн нь ирэх онд Ковид-19 цар тахалд зарцуулахаар байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 731,805.7 мянган төгрөг болж 49,151.6 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан болон үнэ төлбөргүй авсан хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн дансанд урсгал төсвийн худалдан авалтаар 18,929.9 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 88,460.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 878,178.8 мянган төгрөг болж 137,213.3 мянган төгрөгөөр өссөн нь шинээр нэмэгдсэн үндсэн хөрөнгө, тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 360,580.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээж авсан орлого, нэмэлт санхүүжилтийн орлого, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих орлого байна. Энэ нь Ковид-19 цар тахалтай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 215,924.5 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан цалин, НДШ, байр ашиглалттай холбоотой зардал, хангамжийн бараа материалын зардал, нормативт зардал, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл зэрэг зардлууд байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 448,080.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн санал 448,080.2 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотгол хийж 830.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 448,911.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалингийн зардал бууруулж баталсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 448,911.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 390,201.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 32,729.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 25,979.8 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 390,201.9 мянга, орон нутгийн төсвөөс 32,729.3 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 25,979.0 мянга, нийт 446,719.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 446,719.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4,284.9 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 446,719.1 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 191,098.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс урамшууллын зардалд 15,741.0 мянга, НДШ зардалд 4,500.0 мянга, хангамж, бараа материалын зардал 12,064.2 мянга, нормативт зардал 70,454.1 мянга, эд хогшил худалдан авах зардал 24,384.5 мянга, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 30,800.0 мянга, нийт 190,143.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 954.2 мянган төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2020 оны санхүүгийн тайлангаар зөвлөмж өгсөн тул тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Ерөнхий чиглэлийн хавсралт 1 маягтаар 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад зөрчил илрээгүй болно.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 150 мэдээллээс хугацаандаа оруулсан 136, хугацаа хоцроож мэдээлсэн 13, хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөрчил арилгах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамтаар ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын 68,044.7 мянган төгрөгийн авлага тусгагдсан байна. 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,157.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,526.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 4,630.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж байна.

4.2 Төлбөрийн акт

Нийгмийн даатгалын тухай хуулийн 15.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө” гэж заасныг зөрчин даатгуулагчаас төлөх 862.8 мянган төгрөг, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 14 дүгээр зүйлийн 14.1. дэх заалтад “Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна” гэж заасныг зөрчин олгосон цалингаас 663.9 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар тооцоогүй байсанд төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулж ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчин 4630.5 мянган төгрөгийн 1890 литр шатах тослох материалыг олгохдоо

жагсаалт үйлдээгүй, зарцуулахдаа замын хуудас хөтлөөгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй хяналтгүйгээр зарцуулсанд албан шаардлага өглөө.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Увс аймгийн Ойрад хөгжимт жүжгийн театрын	2	6,157.2			1	1,526.7	1	4630.5		
	ДҮН	2	6,157.2			1	1,526.7	1	4630.5		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/Ч.МӨНХТОГТОХ/

2022 оны 02 сарын 25-ны өдөр